



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/84

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа
сунгах тухай


Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.5, 15 дугаар зүйлийн 15.5.1, Нотариатын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэ тушаалын 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 228 нотариатчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2018 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө гээгдүүлсэн нэр бүхий 5 нотариатчийн тусгай зөвшөөрлийг 2 дугаар хавсралтад заасан ёсоор нөхөн олгож үйл ажиллагаа эрхлэх хугацааг 2018 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

3. Тушаалын биелэлтийг хангаж ажиллахыг Монголын нотариатчдын танхим /Р.Онончимэг/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Баясгалан/-д даалгасугай.


Ц.НЯМДОРЖ